



**Нийтлэлийн
сэдэв, гол
санааг түлхүүр
үг, өгүүлбэрээр
тодорхойлох**



Миний эх орон - миний тоонот



Уран нийтлэл гэж юу вэ?

Зохиогчийн уран сэтгэмж, үзэл бодол, үнэлэмж дүгнэлт давамгайлсан олон түмний урмыг сэргээж, ухааныг тэлсэн чөлөөт уран зураглал, бодит баримт хоёрыг хослуулсан тайлбар бүхий нийтлэл- уран сайхны богино эх юм.

Улс төрийн уран нийтлэл

Уянгын уран нийтлэл

Миний эх орон-
миний тоонот

Байгаль нийгмийн хөгжлийн зүй тогтол, хүний амьдралын утга учир, хүн байгалийн харилцаа холбоо, хүний сэтгэлийн нарийн нандин бодол, санааг туйлдаа хүртэл цэнэгшсэн тунгаамал үгээр гаргадаг.

Сэдэв гэж юу вэ?

Өгүүлэгдэж буй гол юмнаас үүдэлтэй санааг хэлнэ. Сэдэв нь юуны тухай? гэсэн асуултад хариулагдана.



Гол санаа гэж юу вэ?

Сэдвээр дамжуулан гаргасан дүгнэлт санааг хэлнэ.


Түлхүүр үг гэж юу вэ?

Тухайн эхийн утга агуулгыг гаргахад чухал үүрэгтэй, олон давтагдаж орсон үгийг хэлнэ.

Түлхүүр өгүүлбэр гэж юу вэ?

Тухайн эхийг бүрдүүлэгч цогцолбор бүрийн гол утгыг мэдээлж байгаа өгүүлбэрийг хэлнэ.

Түлхүүр үгийг ашиглан, эхийн гол санааг тодорхойлоорой.



Гол санаа гэдэг нь сэдвээр дамжуулан гаргасан дүгнэлт санааг хэлнэ.

Гол санааг тайлбарлахдаа:

1. Эхээс гол санааг агуулсан өгүүлбэрийг олох
2. Түлхүүр үгийг ажиглан, өөрөө дүгнэлт хийх
3. Утга тохирох хэлц үгээр илэрхийлэх

“Алтай, хангай, говь, тал. Миний эх орон- миний тоонот.” гэсэн төгсгөл хэсэгт байгаа дүгнэлт бол эхийн гол санааг агуулсан өгүүлбэр гэдэг нь харагдаж байна.

Алтай, хангай, говь, талтайгаа би хүйн холбоотой.

АНХААРЛАА ХАНДУУЛСАН
ТА БҮХЭНДЭЭ БАЯРЛАЛАА.